

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
ДАРГА
2023 оны 05 дугаар сарын 01



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ӨЛЗИЙТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРАЛ**

УДИРДАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар 01

Улаан-Уул

Г “Иргэдийн оролцоотой-Сумын төвийн шинэчлэл” төслийн өнөөгийн байдал цаашдын зорилт, бидний оролцоо нээлттэй хэлэлцүүлэг.

Нэг. Хэлэлцүүлгийн зорилго:

Иргэдийн оролцоотой-Сумын төвийн шинэчлэл төслийн хүрээнд хэрэгжсэн инженерийн шугам сүлжээний ашиглалт, ногоон байгууламж, зам талбайн өргөтгөл, хамгаалалтын өнөөгийн байдлыг хэлэлцэн цаашдын бодлого үйл ажиллагааг төлөвлөх, иргэд бидний оролцоо ямар байх вэ? гэдэгт хэлэлцүүлгийн зорилго оршино.

Хоёр. Хамрах хүрээ:

Иргэд: Сумын төвд амьдарч байгаа өрх бүрээс 1-ээс доошгүй иргэн оролцох. Дулаан хэрэглэгч айл өрхүүдээс, сумын төвийн хөршийн ахлагч нар.

Сумын удирдлагууд: ИТХ-ын дарга, Төлөөлөгчид, Засаг дарга, Тамгын газрын дарга, Сургуулийн захирал, Цэцэрлэгийн эрхлэгч, ЭМТ-ийн дарга, Соёлын төвийн эрхлэгч, багийн Засаг дарга нар

Сумын төвд үйл ажиллагаа явуулж байгаа ААН-үүд: Холбооны салбарын эрхлэгч, Гүн зэгстэй ШТС-н эрхлэгч, Шижир-Ойл ШТС-н эрхлэгч, Өлзийт фарм ХХК-ний захирал, Доржинчангийн хурал хийдийн тэргүүн, ЗЭББ ХХК-ний захирал, Наран төгрөг дэлгүүрийн эзэн, Дэлгэрэх дэлгүүрийн эзэн, Баялаг дэлгүүрийн эзэн, Чандмань дэлгүүрийн эзэн, Дулаан түгээгч компанийн захирал, ажилчид

Төрийн байгууллагуудын алба хаагчид: ИТХ, ЗДТГ, Сургууль, Цэцэрлэг, ЭМТ, Соёлын төвийн ажилтан албан хаагчид, сумын цагдаагийн хэсэг

Гурав. Хугацаа:

2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн 10.00 цагаас сумын Соёлын төвд болно.

642319002

Дөрөв. Хэлэлцүүлгийн журам танилцуулах:

Хэлэлцүүлгийг хөтөлж явуулах ажилтан.

Тав. Хэлэлцүүлгийн мэдээлэл:

- Инженерийн шугам сүлжээний ашиглалт, хамгаалалт цаашид авах арга хэмжээ /Илтгэгч: Сумын Засаг дарга/
- Дулаан үйлдвэрлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл /Илтгэгч: Дулаан үйлдвэрлэл явуулж байгаа ААН-н захирал/
- Сумын ногоон байгууламжийн арчлалт, хамгаалалт өнөөгийн байдал /Илтгэгч: Байгаль хамгаалагч/
- Нийтийн эзэмшлийн зам талбайн ашиглалт /Илтгэгч: Сумын Засаг дарга/
- Ариун цэврийн байгууламжийн ашиглалт хамгаалалт /Илтгэгч: Сумын Засаг дарга/
- Өрхүүдийн хашаа цэгцлэлтийн талаар /Илтгэгч: 6 дугаар багийн Засаг дарга/

Гарц шийдэл:

Хэлэлцсэн асуудлаар цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргах шаардлагатай гэж үзвэл ИТХ-ын хуралдаанд асуудал тавьж шийдвэрлүүлэх.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

СУМЫН ИТХ-ЫН АЖЛЫН АЛБА, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЭРЭГЛЭГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ НИЙГЭМЛЭГ